



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А1420

Номгон

“Ус ашиглагч томоохон аж ахуйн нэгжүүдийн
ус ашиглалтад хяналт тавих тухай”

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчийн хурлын 2023 оны “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 15/42 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ус ашиглагч томоохон аж ахуйн нэгжүүдийн ус ашиглалтын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх ажлыг 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.


2. Дээрх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Ус ашиглагч томоохон аж ахуйн нэгжүүдийн ус ашиглалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулахад шаардагдах 5,000,000 (Таван сая) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

4. Хяналт шалгалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулж, холбогдох тайланг 2023 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн дотор Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Ням-очир)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

64231122

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Ням-очир Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны дарга

Гишүүд:

Б.Намуун Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Г.Нансалмаа Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны Гадаргын усны нөөц, хяналт шинжилгээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

М.Зүгдоржав Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны асуудал, Төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн

Л.Энхтогтох Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны Усны чанар, экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

М.Дүүрэн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны Газрын доорх усны нөөц, хяналт шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн

Холбогдох сумын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга:

Ц.Доржнамжин Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны Уул уурхайн, эрчим хүчний ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн

_____оОо_____